

САНГИЙН САЙД, САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2015 оны 11 сарын 9 өдөр

Дугаар 306 / 307

Улаанбаатар хот

Маягт, заавар батлах тухай

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2, 16 дугаар зүйлийн 16.1.2, Даатгалын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Даатгалын компанид мөрдөгдөх “Нягтлан бодох бүртгэлийн заавар”-ыг нэгдүгээр, “Дансны жагсаалт”-ыг хоёрдугаар, “Санхүүгийн тайлангийн маягт, тодруулга”-ыг гуравдугаар, “Санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх аргачлал”-ыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Тус заавар, маягтыг 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн даатгалын компанийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтийн талаар мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, хяналт тавьж ажиллахыг Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /Х.Пүрэвсүрэн/, Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалтын газар / Б.Оюунцацрал /-т үүрэг болгосугай.

